



DENACODE NUDDIS

Асран хамгаалагчийн гарын авлага

Nuddis гэж юу вэ?

Nuddis бол Bollnäs хотын захиргааны сургуулийн өмнөх боловсролын ирцийн тоон систем юм. Ирц бүртгэлийн тоон системийн зорилго бол удирдлагын хуваарилалтыг хялбаршуулж, хүүхдүүдийн ирцийг хангах юм.

Nuddis ажилтнаар дамжуулан үйл ажиллагаа төлөвлөхийг хялбаршуулах мэдээлэлд нэвтрэх эрх авна. Ирсэн ба тарсан цаг, цэцэрлэг дээр хэдэн хүүхэд хоол идэх зэрэг хүүхдийн ирцийн талаар тодорхой мэдээлэлд нэвтрэх болно. Үйл ажиллагаа болон бусад зүйлийг төлөвлөхийн тулд ажилтан танай хүүхдийн хуваарьт тохирсон цагт нэвтрэх шаардлагатай.

Nuddis бол ухаалаг утасны апп (iPhone ба Android) бөгөөд iPad-уудад ашиглагдана. Таныг хууль ёсны асран хамгаалагч болгох өөрчлөлтүүдийг цэцэрлэг дээр ажилтан автоматаар шинэчилнэ. Систем доторх хөдөлгөөнийг шифрлэсэн учраас нууцлалын өндөр зэрэглэлтэй. Nuddis-ийг энгийн, хэрэглэгчид хялбар байхаар зохион бүтээсэн. Энэхүү гарын авлага нь системийн функцийн талаарх тойм болон Nuddis-ийг хэрхэн ашиглаж эхлэх талаарх мэдээллийг өгнө.



Өдрийн эхэнд бас төгсгөлд

Танай хүүхдийг ирэх ба тарах бүртгэлийг оруулж гаргахын тулд Nuddis-ийн ажилтнууд iPad дээр танай хүүхдийн зураг дээр “дарж” гүйцэтгэнэ. Зурган дээр дарж оруулж гаргах ажлыг та болон танай хүүхэд уг бүртгэлийг хийх үүрэгтэй хүний хамтаар гүйцэтгэнэ.

Nuddis-ийн чухал мэдээлэл

Танай хүүхэд болон асран хамгаалагчийн мэдээллийн нийслэлийн захиргаанаас удирддаг *Skolplatsen* оюутны бүртгэлээс автоматаар оруулна. Ингэснээр Nuddis таны тухай шинэчилсэн мэдээллийг агуулж, та уг мэдээллийг *Skolplatsen* руу өөрөө заавал оруулах ёстой. Энэ мэдээллийг шинэчилсэн эсэхийг та тогтмол нягтлах үүрэгтэй. Та *Skolplatsen* руу URL: <https://bollnas.skolplatsen.se> сайтаар нэвтэрч болно.

Харшил зэрэг тодорхой, чухал мэдээллийг асран хамгаалагч тантай зөвлөлдсөний дагуу Nuddis-д ажилтан бүртгүүлнэ.

Nuddis апп

Та Nuddis апп ашиглан хүүхдийнхээ тухайн өдрийн хуваарийг оруулах, тухайн өдөрт ажилтанд мэдэгдэх шаардлагатай чухал мэдээллийг илгээхэд ашиглаж болно.

iOS (iPhone юмуу iPad)-д зориулсан апп нь App Store-д орсон. Android-ын апп нь Google Play-д орсон.



Нэвтрэх

Асран хамгаалагчийн хувьд та өөрийн BankID ашиглан Nuddis апп руу нэвтэрч, зөвхөн өөрийнхөө хүүхдийн тухай мэдээллийг харах боломжтой болно. Нэвтэрсэн үедээ бүртгэлийн нэрээ хэлэхийг хүссэн үед та дараах нэрийг оруул: **bollnas**. Хэрвээ танд BankID ашиглах сонголт байхгүй бол та цэцэрлэг дээр ажилтантай холбогдон тусламж авч болно.


iPhone/iPad ашиглан Nuddis ашиглах

Хэрвээ та Android апп ашигладаг бол дараагийн хэсэг рүү оч.

iOS аппаар асран хамгаалагч болж нэвтэрсэн үед та таван табыг харна: *Хуваарь, Тойм, Түүх, Миний Хөрөг* ба *Тусламж*.

ХУВААРЬ

Танай хүүхдийн мэдээллийн эхний тоймыг энд харуулна. Хуваарийг харах юмуу өөрчлөхийн тулд хүүхдийг сонго.



Хуваарь нэмэхийн тулд хуанли дээрээс холбогдох өдөр дээр дараад цагийг сонгож, хэн хүргэж өгч, хэн авахыг бөглөөд “Үүсгэх” товчлуурыг дарж төгсгөнө.

Хэд хэдэн өдрийн турш нэг цаг ашиглахыг хүсвэл “Хуулах” товчлуур дээр дар. Хуулж авахын тулд эхлээд өдрийг сонгоод дараа нь хуулж оруулахыг хүссэн өдрийг сонгож “Дараагийн” товчлуурыг дар. Хэрвээ танд хэд хэдэн хүүхэд байгаа бол та тэр цагийг бусад хүүхдүүд рүү хуулж болно. “Дараагийн” товчлуурыг дахин дараад та одоо нэг өдрөөс эхлэн нэг юмуу хэд хэдэн өдрөөр хуулж авлаа.

Энэ маягаар та бүтэн долоо хоногоос хэд хэдэн дараалсан долоо хоног хүртэл цагийг хуулж болно. “Хуулах” товчлуур дээр дараад дараа нь “Бүтэн долоо хоног”-ийг сонго. Дараагийн шатанд та цагийг хуулахыг хүссэн долоо хоногийг болон хэрэглэхийг хүссэн интервалаас сонгож болно.

Kopiera från vecka

Hela veckan Vecka 12 (19/3 - 25/3) >

Måndag (Markerad) 19/3 >

Kopiera till vecka

Vecka 12 Vald vecka >

Vecka 13 26/3 - 1/4 >

Med intervall

Varje vecka >

Varannan vecka >

Var tredje vecka >

Var fjärde vecka >

Var femte vecka >

Тасалсан Тайлан

Хэрвээ танай хүүхэд өвдсөн юмуу чөлөө авсны улмаас бүтэн өдөр ямар нэгэн шалтгаанаар хичээлд ирэхгүй бол та өөрчлөлтийг даруй мэдээлэхийг хүсэж байна, ингэснээр ажилтан үйл ажиллагааг төлөвлөж эхэлнэ.

Хичээл тасалсан тайланг тухайн өдрийг хуваарь дээрээс дараад “чөлөө авсан” юмуу “Тасалсан/Өвчтэй” товчлуураас сонгож “Өөрчлөх” товчлуур дээр дарснаар дуусгана.

Таны оруулсан өөрчлөлтийг цэцэрлэг дээр Nuddis апп дотор шууд шинэчлэх ч тасалсан тохиолдолд хэрхэн харилцах талаар цэцэрлэг дээр ажилтанд үзүүлээрэй. Тасалсан/өвдсөн тайлан юмуу чөлөөтэй тайланг хуваарь товлосон өдөрт хийх шаардлагатай.

Ledig	Frånvaro / Sjuk
Närvaro - Tisdag 3/4	
Från	08:00
Till	16:00
Lämnar	
Hämtar	
Dagsinfo till personal	
ÄNDRA	
TA BORT	

Аль хэдийн товлосон өдрүүдийн хувьд ажилтанг мэдэж байхад шаардлагатай чухал мэдээлэл бүхий товч зурвасыг бас үлдээж болно. Та энэ мэдээллийг талбарт оруулж болно, “Ажилтанд зориулсан өдөр тутмын мэдээлэл”. Чухал мэдээллийн жишээнээс

ТЭМДЭГЛЭЛ! Ийм мэдээллийг цуглуулах зорилго нь зөвхөн цэцэрлэгт байгаа бусад хүүхдүүдийн дунд уг халдварын тархалтыг хязгаарлах юм. Энд та ажилтантай харилцааг хэрхэн зохицуулах талаар тэдэнтэй ярилцах ёстой.

дурдвал гэдэс өвдсөний улмаас танай хүүхэд хичээл тасалсан.

ТОЙМ

Энд дараагийн хэд хоног танай хүүхдийн хуваарийн энгийн тоймыг харж болно.

ТҮҮХ

Эндээс та өөрийн төлөвлөсөн хуваарьтай өнгөрсөн хэдэн долоо хоногт хүүхдээ хэрхэн хүргэж өгч, авсан талаар заасан статистикийг харж болно.

МИНИЙ ХӨРӨГ

Эндээс та Nuddis доторх тантай холбоо барих мэдээллийг зөв эсэхийг шалгаж болно. Мэдээлэл дутуу байвал Skolplatsen руу нэвтэрч тэнд мэдээллээ шинэчлээрэй. Nuddis үг мэдээллийг автоматаар шинэчилнэ.

Android аппаар дамжуулан Nuddis ашиглах

Android апп дараах табуудтай: *Хуваарь* ба *Мэдээлэл*.

ХУВААРЬ

Танай хүүхдийн мэдээллийн эхний тоймыг энд харуулна. Хуваарийг харах юмуу өөрчлөхийн тулд хүүхдийг сонго.

Хуваарь нэмэхийн тулд хуанли дээрээс холбогдох өдөр дээр дараад цагийг сонгож, хэн хүргэж өгч, хэн авахыг бөглөөд “Нэмэх/Өөрчлөх” товчлуурыг дарж төгсгөнө.


Та бүтэн долоо хоногоос хэд хэдэн дараалсан долоо хоног хүртэл цагийг хуулж болно. Зурган жишээн дэх 37 дахь долоо хоног зэрэг долоо хоногийн тоог заасан бараан саарал шугам дээр дараад аль долоо хоногийн цагийг хуулахыг хүсэж байгаагаа мөн нэгээс олон хүүхдэд хамаарах бол түүнийг сонго.

Тасалсан Тайлан

Хэрвээ танай хүүхэд өвдсөн юмуу чөлөө авсны улмаас бүтэн өдөр ямар нэгэн шалтгаанаар хичээлд ирэхгүй бол та өөрчлөлтийг даруй мэдээлэхийг хүсэж байна, ингэснээр ажилтан үйл ажиллагааг төлөвлөж эхэлнэ.

Хичээл тасалсан тайланг тухайн өдрийг хуваарь дээрээс дараад “чөлөө авсан” юмуу “Тасалсан/Өвчтэй” товчлуураас сонгож “Өөрчлөх” товчлуур дээр дарснаар дуусгана.

Таны оруулсан өөрчлөлтийг цэцэрлэг дээр Nuddis апп дотор шууд шинэчлэх ч тасалсан тохиолдолд хэрхэн харилцах талаар цэцэрлэг дээр ажилтанд үзүүлээрэй. Тасалсан/өвдсөн тайлан юмуу чөлөөтэй тайланг хуваарь товлосон өдөрт хийх шаардлагатай.



Аль хэдийн товлосон өдрүүдийн хувьд ажилтанг мэдэж байхад шаардлагатай чухал мэдээлэл бүхий товч зурвасыг бас үлдээж болно. Үүнийг “Сэтгэгдлүүд” талбараар дамжуулан хийнэ. Чухал мэдээллийн жишээнээс дурдвал гэдэс өвдсөний улмаас танай хүүхэд хичээлд ирээгүй.

ТЭМДЭГЛЭЛ! Ийм мэдээллийг цуглуулах зорилго нь зөвхөн цэцэрлэгт байгаа бусад хүүхдүүдийн дунд уг халдварын тархалтыг хязгаарлах юм. Энд та ажилтантай харилцааг хэрхэн зохицуулах талаар тэдэнтэй ярилцах ёстой.

МЭДЭЭЛЭЛ

Nuddis-ийн талаар товч мэдээлэл болон мэдэгдлийг асаах/унтраах, гарах зэрэг мэдээлэл энд бий.

ТҮГЭЭМЭЛ АСУУГДДАГ АСУУЛТУУД

Хэрвээ надад BankID авах сонголт байхгүй бол би хэрхэн хуваарьт нэмэх вэ?

Хэрвээ танд BankID авах сонголт байхгүй бол таныг юу хийх ёстойг танд хэлж өгөх цэцэрлэгийн ажилтантай ярилцаарай.

Дараагийн хоёр хоногт хэрхэн хуваарь нэмж/өөрчилж яагаад болохгүй байгаа юм бол?

Үйл ажиллагааг төлөвлөх чадамжтай болохын тулд цэцэрлэгээс хамгийн багадаа 2 хоногийн өмнө урьдчилан таны хуваарьт өөрчлөлт оруулах талаар мэдэгдэх шаардлагатай. Хэрвээ та хоёр өдрөөс богино хугацаанд мэдэгдэн хуваарьт өөрчлөлт оруулахын тулд цэцэрлэгийн ажилтантай холбогдоно уу.

Ажилтан руу зурвас хэрхэн илгээх вэ?

Апп дотор богино зурвас үлдээж болно. Сэтгэгдлийн талбарт зурвасыг оруулна уу, “Ажилтанд өгөх өдөр тутмын мэдээлэл” (iOS) юмуу “Сэтгэгдлүүд” (Android). Зурвасыг Nuddis апп дотор хүүхдийн зургийн хажуугийн ярианы хөөсөн дотор цэцэрлэгийн ажилтанд харагдана.

Би аппаар дамжуулж хүүхдийнхээ тасалсан/өвдсөн тайланг гаргаж болох уу?

Тийм ээ, ингэх боломжтой. Хичээлд очихгүй байх талаар аль болох эрт мэдэгдвэл ажилтан үйл ажиллагааг төлөвлөж болно. “Чөлөө авсан” юмуу “Тасалсан/Өвчтэй” товчлуураас сонгож “Өөрчлөх” дээр дар.

Хэрвээ би хүүхдээ орж гарах бүртгэлийг нь хийхээ мартсан яах вэ?

Ажилтантай холбогдвол тэд танд тусална.

Би яагаад хүүхдийн тасалсан цагийн талаар и-мэйл хүлээн авч байна вэ?

Системээс таны и-мэйл хаяг руу сануулга илгээнэ. Хамгийн сүүлд таныг цаг товлохоос долоо хоногийн өмнө системээс одоо шинэ хуваарь оруулах цаг болсон талаар сануулга илгээнэ. Хэрвээ та амралтын өдөр зэрэгт сануулга хүлээн авахыг хүсэхгүй байгаа бол танай хүүхдийг хуваарь дээр тасалсан гэж тэмдэглэнэ.

Манай хүүхдийн мэдээлэл Nuddis дотор хэр удаан хадгалагдах вэ?

Танай хүүхдийн талаар мэдээллийг 3 жил хадгална. Тэр цагаас хойш мэдээллийг танигдахгүй болгож, статистикийн зорилгоор ашиглахаар хадгална.

Боловсролын газартай холбогдоно уу

Тусламжийн асуудлыг дараах хаягаар илгээнэ: support.utbildningskontoret@bollnas.se

Асуудлынтодорхойлолтыг тодорхойлж, ямар нэгэн зүйл буруудсан үед та юу хийсэн, ямар төрлийн гар утас юмуу таблет ашиглаж байсан, өмнө нь ажиллаж байсан эсэх зэрэг мэдээллийг тодорхой өгнө үү.